



## ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.07.26 № 01/1401

таний —ны № —т

### ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

#### Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус компаниас зарласан ЭТТХК/20240103011 дугаартай Үйлдвэрлэл технологийн паркийн зөрлөг, нүүрс баяжуулах үйлдвэрийн ачилтын төмөр замын ажлын зураг төсөв боловсруулах үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Хариу
1	3.10-т “Геологи, геодезийн хайгуулын ажлын тайланг гэрээ зурагдсанаас хойш 8 долоо хоногийн дараа захиалагчид ирүүлэх” гэж болон “Ажлын зураг төслийг гэрээ зурагдсанаас хойш 12 долоо хоногийн дараа захиалагчид ирүүлэх” гэж тус тус заасан. Гэвч 3.9-т “Зураг төслийн өмнөх зарчмын судалгааны ажлыг 5 долоо хоногт хийж гүйцэтгэх” гэж болон “Зураг төслийг 2-оос багагүй хувилбар гаргаж 2 долоо хоногийн дараа захиалагчид ирүүлж, захиалагчаар сонгуулж, батлуулах” гэж тус тус заасан байна. Үүнээс дүгнэхэд геологи, геодезийн ажлыг 1 долоо хоногт, ажлын зургийг 5 долоо хоногт тус тус хийхээр уншигдаж байна. Энэ үнэн бодит хугацаа юу?	Гэрээ зурагдсанаас хойш: - Салбар төмөр замын трассын судалгааг 2 долоо хоногт - Захиалагчаас эцсийн трассыг сонгоход 1 долоо хоног. - Сонгогдсон трасс дээр геологи, геодезийн хайгуулын ажлын тайланг 3 долоо хоногт, - Ажлын зургийг боловсруулан баталгаажуулах ажлыг 6 долоо хоногт;
2	3.11-т “Төмөр зам барих газар сонгосон мэргэжлийн багийн дүгнэлт, хурлын шийдвэр” гэж юуг хэлж байгаа вэ?	Трассын судалгаанд 2-оос доошгүй хувилбараас нэгийг нь сонгох баг бүрэлдэхүүн ажиллах бөгөөд энэхүү багийн дүгнэлтийг гэж ойлгоно.
3	3.11-т Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг боловсруулж батлуулах хугацаа хэдий хугацаатай вэ? Гэрээний хугацаанд амжихгүй болов уу гэж тооцож байна.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хувилбар сонгосон даруйд эхлүүлж болох бөгөөд 1 дүгээр асуултын хариултад дурдсанаар нийт ажил гүйцэтгэх хугацаатай ижил буюу 12 долоо хоног байна.

1124042519

4	3.11-т “№18/04/02 дугаартай салбар төмөр зам барих хамтарсан ажлын хэсгийн дүгнэлт” гэж юу вэ? Салбар төмөр зам барих техникийн нөхцөл мөн эсэх?	2 дугаар асуултын хариултад дурдсан Салбар төмөр замын хувилбар сонгох багийн дүгнэлт гэж ойлгоно. Энэ нь техникийн нөхцөл биш.
5	Ерөнхий төлөвлөлтийн дэвсгэр зураг /Баяжуулах үйлдвэр, төмөр зам багтаасан	Хавсралтаар хүргүүлэв.
6	Төмөр зам, баяжуулах үйлдвэрийн хөдөлгөөнгүй цэгийн координатууд	Хавсралтаар хүргүүлэв.

Тендер шалгаруулалтын зааварчилгааны 11.1-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ